



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК-ИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/28/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Их монгол хөлөг аудит ХХК
Захирал: С.Тунгалаг Цахим хаяг: info@imkaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	13
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт	14
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ
ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.ЦЭНГҮҮНЖАВ ТАНАА

2022.03.15 № 07/566
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд нийт орлогыг 1,202.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,105.4 сая төгрөгөөр, ашгийг 96.9 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 1,192.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 790.2 сая төгрөгийн зардал гарган, 401.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг

төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	673,109,872.62	683,643,234.32
1.1.2	Дансны авлага	-	1,770,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	12,157,432.43
1.1.6	Бараа материал	10,757,575.82	43,670,306.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	22,435,905.36	30,313,572.70
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	706,303,353.80	771,554,545.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	330,278,502.82	619,414,847.05
1.2.2	Биет бус хөрөнгө	1,187,638.33	10,903,819.12
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	48,407,494,354.07	48,407,494,354.07
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,738,960,495.22	49,037,813,020.24
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	49,445,263,849.02	49,809,367,566.08
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	2,427,250.65
2.1.1.2	Цалингийн өглөг	1,163,891.28	1,163,891.12
2.1.1.3	Татварын өр	5,086,854.06	38,401,993.57
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	150,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,250,745.34	42,143,135.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,250,745.34	42,143,135.34
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	1,000,000.00	49,373,854,300.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	48,729,038,901.60	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	708,974,202.08	393,370,130.74
2.3.10	тайлант үеийн ашиг, алдагдал	-	361,349,467.06
2.3.11	Эздийн өмчийн дүн	49,439,013,103.68	49,767,224,430.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	49,445,263,849.02	49,809,367,566.08

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	106,659,003.11	21,001,746.15
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	791,134,605.16	1,171,088,829.87
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	183,711,605.49
10	Ерөнхий ба удирдлагын зардал	728,411,734.08	606,509,844.62
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	199,322,176.84	(17,502.07)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	368,704,051.03	401,851,623.84
19	Орлогын татварын зардал	37,322,630.14	40,502,156.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)	331,381,420.89	361,349,467.06
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	331,381,420.89	361,349,467.06

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

					<i>/төгрөгөөр/</i>
	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	45,272,410,521.60	377,592,781.19	45,651,003,302.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	45,272,410,521.60	377,592,781.19	45,651,003,302.79
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	3,456,628,380.00	-	3,456,628,380.00
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	331,381,420.89	331,381,420.89
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	48,729,038,901.60	708,974,202.08	49,439,013,103.68
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	48,729,038,901.60	708,974,202.08	49,439,013,103.68
13	Өмчид гаргасан өөрчлөлт	49,372,854,300.00	(48,729,038,901.60)	(643,815,398.40)	-
14	Зарласан ногдол ашиг	-	-	(33,138,140.00)	(33,138,140.00)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	361,349,467.06	361,349,467.06
17	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	49,373,854,300.00	-	393,370,130.74	49,767,224,430.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,249,957,048.34	1,192,744,040.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	229,565,970.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	3,456,628,380.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	793,328,668.34	963,178,070.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	736,855,995.55	804,881,428.64
1.2.1	Ажиллагсад төлсөн	350,595,214.74	356,128,513.95
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	91,256,672.76	104,291,557.22
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	44,446,126.34	102,606,879.92
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	124,687,080.00	115,895,914.55
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,434,769.00	10,685,813.27
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	67,176,143.39	48,653,643.59
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,682,096.00	4,552,746.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	52,577,893.32	62,066,360.14
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,513,101,052.79	387,862,611.36
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	106,659,003.11	21,001,746.15
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	106,659,003.11	21,001,746.15
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,279,227,980.00	365,175,353.74
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	162,312,140.00	354,965,353.74
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,210,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	13,116,915,840.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,172,568,976.89)	(344,173,607.59)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	199,322,176.84	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	199,322,176.84	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	33,155,642.07
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	33,138,140.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	17,502.07
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	199,322,176.84	(33,155,642.07)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(9,460,145,747.26)	10,533,361.70
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,133,255,619.88	673,109,872.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	673,109,872.62	683,643,234.32

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	1,097,115.8	1,202,262.9	1,192,090.6	(10,172.3)	99.2
1.1	Засгийн газрын санхүүжилт	мян.төг	790,500.0	949,262.9	949,262.9	-	100.0
1.2	Хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого	мян.төг	-	248,000.0	221,337.2	(26,662.7)	89.2
1.3	Хүүгийн болон бусад орлого	мян.төг	107,293.6	5,000.0	21,490.4	16,490.4	429.8
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	мян.төг	199,322.2	-	-	-	-
2	Нийт зардал	мян.төг	728,411.7	1,105,373.9	790,221.5	(315,152.4)	71.5
2.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	мян.төг	728,411.7	828,370.0	540,187.0	(288,182.9)	65.2
2.2	Хүндэт зочны танхимын үйл ажиллагааны зардал	мян.төг	-	229,135.9	183,711.6	(45,424.2)	80.2
2.3	Элэгдлийн зардал	мян.төг	44,523.5	47,868.0	66,322.8	18,454.8	138.6
3	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	мян.төг	368,704.1	96,889.0	401,869.1	304,980.1	414.8
4	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/	мян.төг	-	-	(17.5)	(17.5)	-
5	Нийт ашиг (алдагдал)	мян.төг	368,704.1	96,889.0	401,851.6	304,962.6	414.8
6	Орлогын албан татвар	мян.төг	37,322.6	9,688.9	40,502.2	30,813.2	418.0
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	331,381.4	87,200.1	361,349.5	274,149.3	414.4
8	Ногдол ашиг	мян.төг	-	8,720.0	36,134.9	27,414.9	414.4
9	Авлага	мян.төг	-	1,000.0	13,927.4	12,927.4	1,392.7
10	Өглөг	мян.төг	6,250.7	5,000.0	42,143.1	37,143.1	842.9
10.1	Урт хугацаат	мян.төг	-	-	-	-	-
10.2	Богино хугацаат	мян.төг	6,250.7	5,000.0	42,143.1	37,143.1	842.9
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	162,912.1	486,037.0	399,334.4	(86,702.6)	82.2
12	Цалингийн сан	мян.төг	427,610.2	585,840.0	345,468.3	(240,371.6)	59.0
13	Ажиллагсдын тоо	хүн	14	41	27	(14)	65.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн програм хангамж, борлуулалтын орлого, зорилтот түвшин, авлага, өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, туслах аудитор Г.Ариунболд, Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Сожидмаа, захирал С.Тунгалаг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан зорилтот түвшний нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны зорилтот түвшний нийт зардал 1,105.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн зорилго нь дэлхийд тэргүүлэгч нисэх буудлын менежменттэй үндэсний компани болоход оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг шинэ нисэх буудлын менежмент хэрэгжүүлэх хамтарсан компанийн 49 хувийг эзэмших, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах ба нисэх буудлаар үйлчлүүлэгчдэд олон улсын стандарт, шаардлагын түвшинд хүрсэн, аюулгүй байдлыг хангасан, тав тухтай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангуулах гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн статустай байна.

Өмчийн 66 хувийг Зам тээврийн хөгжлийн яам, 34 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 150 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг хувьцаа эзэмшигчид томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.3-т “компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг сонгох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох” гэж заасантай нийцэж байна.

“Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд холбогдох шийдвэрүүдийн хэрэгжилтийн биелэлтийг цаг тухай бүр нь гаргаж ЗТХЯ, ТӨБЗГ болон төрийн хяналтын байгууллагууд албан тоотоор хүргүүлэн хэрэгжилтийн ханган ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 27 хүртэл бууруулан ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	673,109.9	683,643.2	10,533.4
Дансны авлага	-	1,770.0	1,770.0
Татвар, НДШ-ийн авлага	-	12,157.4	12,157.4
Бараа материал	10,757.6	43,670.3	32,912.7
Урьдчилж төлсөн зардал тооцоо	22,435.9	30,313.6	7,877.7
Үндсэн хөрөнгө	330,278.5	619,414.8	289,136.3
Биет бус хөрөнгө	1,187.6	10,903.8	9,716.2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	48,407,494.4	48,407,494.4	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	49,445,263.8	49,809,367.6	364,103.7
Дансны өглөг	-	2,427.3	2,427.3
Цалингийн өглөг	1,163.9	1,163.9	-
Татварын өр	5,086.9	38,402.0	33,315.1
Урьдчилж орсон орлого	-	150.0	150.0
Төрийн өмч	1,000.0	49,373,854.3	49,372,854.3
Эздийн өмчийн бусад хэсэг	48,729,038.9	-	(48,729,038.9)
Хуримтлагдсан ашиг	708,974.2	393,370.1	(315,604.1)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	49,445,263.8	49,809,367.6	364,103.7

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 619.3 сая төгрөг, хугацаатай хадгаламжид 58.2 сая төгрөг /20.5 мянган ам.доллар/, бэлэн мөнгөний кассад 6.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 12.2 сая төгрөг, дансны авлага 1.2 сая төгрөг байна.

Тайлант онд хүндэт зочны танхимыг ашиглалтад оруулж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэнтэй холбоотой НӨАТ-ын авлага 12.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 32.9 сая төгрөгөөр өссөн нь хүндэт зочны танхимд ашиглах бараа материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал, тооцооны данс 7.9 сая төгрөгөөр өссөн нь үйлчилгээний автомашины гражийн түрээсийн төлбөрийг урьдчилж, төлснөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Шинэ нисэх онгоцны буудалд ажиллуулж буй хүндэт зочны танхим, түүний орчны тохижуулалтад зориулж 355.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 9.7 сая төгрөгөөр өссөн нь Хүндэт зочны танхимд ашиглах кассын машин, рестораны болон зорчигчийн бүртгэлийн программыг тус тус худалдан авч бүртгэснээс шалтгаалжээ.

Дансны өглөгийн үлдэгдэл 2.4 сая төгрөгөөр өссөн нь хүндэт зочны танхимын ашиглалтын зардлын 12 дугаар сарын нэхэмжлэхийн төлбөрийн үүрэг үүссэнээс шалтгаалсан байна.

Татварын өр 33.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын үлдэгдлээс шалтгаалжээ.

Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн ХЭХТ 20/05 тоот хурлын тогтоолоор нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцааны тоог 493,738 мянган ширхэг, өөрийн хөрөнгийн хэмжээг 49,373.9 сая төгрөг байхаар тогтоож, компанийн дүрэмд өөрчлөлт оруулсан.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ХЭХТ 20/06 дугаар тогтоолоор "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,553.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,456.1 сая төгрөгөөр, 96.9 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 234.9 сая төгрөгийг төлөвлөсөн байна

Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/42/44 дүгээр тушаалаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны Засгийн газрын санхүүжилтийг 350.7 сая төгрөгөөр бууруулж 1,202.3 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 1,192.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 790.2 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны, 0.02 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны, нийт 790.2 сая төгрөгийн зардал гарган 401.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,192.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 10.2 сая төгрөг буюу 0.8 хувиар тасарсан нь Шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагаа 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрөөс эхэлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 790.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 315.2 сая төгрөг буюу 28.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагаа хойшилсон, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хүндэт зочны танхимын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ажилд өөрийн эх үүсвэрээс 365.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 401.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 305.0 сая төгрөгөөр илүү байгаа нь Шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагаа хойшилсон, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан нь нөлөөлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 228 дугаар тогтоолын дагуу 2020 оны цэвэр ашгаас 33.1 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 171 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөшгийн хөндий нисэх онгоцны буудал ТӨХХК нь 2021 онд нийт 2,135.5 сая төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,112.0 сая төгрөгийн 169 мэдээллийг бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй зөрчилтэй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар борлуулалтын орлогыг 1,202.3 сая төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 1,192.1 сая төгрөгийн биелэлттэй буюу орлогын төлөвлөгөө 10.2 сая төгрөг буюу 0.8 хувиар тасарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөвлөсөн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 129.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 95.2 сая төгрөгийн алдааг залруулж, 32.9 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, 1.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн							

/мянган төгрөг/

7. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн санхүүгийн тайлангийн программ хангамж, үндсэн хөрөнгийн элэгдлийн давтан тооцоолол, хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлсэн байгууллагын дотоод журмыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 191.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 189.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 1.8 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 11.1 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 189.6 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант хугацаанд 21 байгууллагаас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 3.7 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтыг зардлаар бүртгэж тайлагнасан;
- Тайлант хугацааны бараа материалын тайлангийн тодруулгыг бараа материалын журналтай тулгахад орлого 2.5 сая төгрөг, зарлага 2.4 сая төгрөгийн зөрүүтэй ба үлдэгдэл 0.04 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн;
- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг нярвын тайлантай тулгахад 0.3 сая төгрөгийн орлого, 0.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ зөрүүтэй бүртгэсэн;
- Тайлант хугацаанд 133 иргэн хуулийн этгээдийн 32.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 20.2 сая төгрөг, 16 иргэн, хуулийн этгээдийн 2.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлээс 0.2 сая төгрөг, нийт 20.3 сая төгрөгийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг төлбөрийн баримтын цахим системтэй тулгахад 69 байгууллагаас 33.4 сая төгрөгөөр илүү, 47 байгууллагаас 9.3 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Түрээс, ашиглалт, засвартай холбоотой 117.2 сая төгрөгийн ажил гүйлгээг шууд зардалд бүртгэж тайлагнасныг тус тус залруулсан.

8.2 Төлбөрийн акт

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.6-д "Туршилтын хугацаагаар болон дагалдан ажилтны цалин тухайн албан тушаалын үндсэн цалингийн 60 хувьтай тэнцүү байна" гэсэн заалтыг зөрчиж 3 ажилтанд нийт 1.3 сая төгрөгийн цалин хөлс илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5.2 дахь заалт "Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба

хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй", Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8.4-т "Шинээр ажилд орсон ажилтыг туршилтын хугацаагаар ажиллуулах ба цалинг цалингийн нэгдүгээр шатлалаар тогтооно. Ажилтны ажлын туршлага, мэдлэг, мэргэшил, ур чадварыг харгалзан Гүйцэтгэх захирал эсхүл Захирлын зөвлөлийн хурлаас гарсан санал дүгнэлт, шийдвэрийн дагуу тухайн ажилтны үндсэн цалинг шууд үндсэн шатлалаар эсхүл шатлал ахиулж тогтоож болно", 8.6-д "Туршилтын хугацаагаар болон дагалдан ажилтны цалин тухайн албан тушаалын үндсэн цалингийн 60 хувьтай тэнцүү байна. Хийснээр цалинжих ажилтанд заалт хамаарахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Цалинг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тооцож байх, илүү олгосон цалинг буцаан төсөвт төвлөрүүлэх Төлбөрийн акт тогтоох.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын бүх ажил гүйлгээг бараа, бэлэн бүтээгдэхүүний /1401000/ дансанд бүртгэж, тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д "Эдийн засгийн салбарын хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлал, маягтыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх", Сангийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 23-ны 249 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт "Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн програмд дэд данс үүсгэж бараа материалыг ангилан бүртгэж байх

2. Борлуулалтын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төлбөрийн баримтын цахим системд борлуулалтын орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлангаас 0.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн" 14.3-д "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг бусад татварын тайлан, дэлгэрэнгүй бүртгэлүүдтэй тулгаж, үнэн зөв тайлагнаж байх.

3. Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын ашиглаж буй Интерактив Би Ай ХХК-ийн Импакт санхүүгийн программаас дэлгэрэнгүй бүртгэл, холбогдох журнал, товчоо тайланг эксел форматад хөрвүүлэхэд Сангийн сайдын тушаалаар батлагдсан маягтуудын дагуу бэлтгэгдэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх", Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 47 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3.4 дүгээр заалтыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан Сангийн сайдын 47 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтэд тусгагдсан санхүүгийн программ хангамжийг ашиглах.

4. Авлага өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 17 иргэн, хуулийн этгээдийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тухай бүрд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй аудитын явцад нөхөж бүрдүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тухай бүрд нь тооцоо нийлж, баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Тайлант жилд 21 байгууллагаас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний 3,668.3 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаалтыг зардлаар бүртгэж тайлагнасан байна.	Залруулсан	1	3,668.3	1	3,668.3	-	-	-	-	-	-	-	-
2	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Тайлант хугацааны бараа материалын тайлангийн тодруулгыг бараа материалын журналтай тулгахад орлого 2,477.9 мянган төгрөг, зарлага 2,438.2 мянган төгрөгийн зөрүүтэй ба үлдэгдэл 39.7 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлэгдсэн байна.	Залруулсан	1	4,916.0	1	4,916.0	-	-	-	-	-	-	-	-
3	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг нярвын тайлантай тулгахад 384.1 мянган төгрөгийн орлого, 374.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ зөрүүтэй бүртгэгдсэн байна.	Залруулсан	1	758.3	1	758.3	-	-	-	-	-	-	-	-

4	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Хөшигийн хөндий нисэх онгоцны буудал ТӨХХК нь 2021 онд нийт 2,135,498.6 мянган төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,112,018.5 мянган төгрөгийн 169 мэдээллийг бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй зөрчилтэй байна.	Залруулсан	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-
5	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 133 иргэн хуулийн этгээдийн 32,083.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс 20,177.9 мянган төгрөг, 16 иргэн, хуулийн этгээдийн 2,427.3 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлээс 150.0 мянган төгрөг нийт 20,327.9 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Залруулсан	1	20,327.9	1	20,327.9	-	-	-	-	-	-	-	-
6	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Хөрөнгө, бараа материалын худалдан авалтыг төлбөрийн баримтын цахим системтэй тулгахад 69 байгууллагаас 33,406.3 мянган төгрөгөөр илүү, 47 байгууллагаас 9,308.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	Залруулсан	1	42,714.7	1	42,714.7								

7	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Түрээс, ашиглалт, засвартай холбоотой 117,175.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.	Залруулсан	1	117,175.2	1	117,175.2	-	-	-	-	-	-	-	-
8	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.6-д "Туршилтын хугацаагаар болон дагалдан ажилтны цалин тухайн албан тушаалын үндсэн цалингийн 60%-тай тэнцүү байна" гэсэн заалтыг зөрчиж 3 ажилтанд нийт 1,269.9 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна.	Төлбөрийн акт тогтоох	1	1,269.9	-	-	1	1,269.9	-	-	-	-	-	-
9	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Бараа материалын бүх ажил гүйлгээг Бараа, бэлэн бүтээгдэхүүний /1401000/ дансанд бүртгэж, тайлагнасан байна.	Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн програмд дэд данс үүсгэж бараа материалыг ангилан бүртгэж байх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
10	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Төлбөрийн баримтын цахим системд борлуулалтын орлогыг орлогын дэлгэрэнгүй тайлангаас 493.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	Санхүүгийн тайланг бусад татварын тайлан, дэлгэрэнгүй бүртгэлүүдтэй тулгаж, үнэн зөв тайлагнаж байх.	1	493.7	-	-	-	-	-	-	-	-	1	493.7

11	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Байгууллагын ашиглаж буй "Интерактив Би Ай" ХХК-ийн "Импакт" санхүүгийн программаас дэлгэрэнгүй бүртгэл, холбогдох журнал, товчоо тайланг экселд хөрвүүлэхэд Сангийн сайдын тушаалаар батлагдсан маягтуудын дагуу бэлтгэгдэхгүй байна.	Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан Сангийн сайдын 47 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтэд тусгагдсан санхүүгийн программ хангамжийг ашиглах.	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
12	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 17 иргэн, хуулийн этгээдийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тухай бүрд нь тооцоо нийлж, баталгаажуулаагүй аудитын явцад нөхөж бүрдүүлсэн.	Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тухай бүрд нь тооцоо нийлж, баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Дүн					12	191,324.0	7	189,560.4	1	1,269.9	-	-	-	-	4	493.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

1	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь 2021 онд нийт 2,135,498.6 мянган төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,112,018.5 мянган төгрөгийн 169 мэдээллийг бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа	Албан шаардлага өгөх	1	46,622.2	-	-	-	1	46,622.2	-	-	-	-	-
---	---	------------------------	--	----------------------	---	----------	---	---	---	---	----------	---	---	---	---	---

			хоцроож, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй зөрчилтэй байна.														
2	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	АХГ-2022/28/НА-СТА-ТӨА	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар борлуулалтын орлогыг 1,202,262.9 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 1,192,090.6 мянган төгрөгийн биелэлттэй буюу орлогын төлөвлөгөө 10,172.3 мянган төгрөг буюу 0.8 хувиар тасарсан байна.	Албан шаардлага өгөх	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн					2	46,622.2	-	-	-	-	2	46,622.2	-	-	-	-	-
НИЙТ ДҮН					14	237,946.2	7	189,560.4	1	1,269.9	2	46,622.2	-	-	4	493.7	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 09 дугаар сарын 15 № 78/АД150458
АХГ-2022/28/НА-СТА-Т6А

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.6 “Туршилтын хугацаагаар болон дагалдан ажилтны цалин тухайн албан тушаалын үндсэн цалингийн 60%-тай тэнцүү байна” гэсэн заалтыг зөрчиж, 3 ажилтанд нийт 1,269,900.00 төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй”, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4 “Шинээр ажилд орсон ажилтныг туршилтын хугацаагаар ажиллуулах ба цалинг цалингийн нэгдүгээр шатлалаар тогтооно. Ажилтны ажлын туршлага, мэдлэг, мэргэшил, үр чадварыг харгалзан Гүйцэтгэх захирал эсхүл Захирлын зөвлөлийн хурлаас гарсан санал дүгнэлт, шийдвэрийн дагуу тухайн ажилтны үндсэн цалинг шууд үндсэн шатлалаар эсхүл шатлал ахиулж тогтоож болно”, 8.6 “Туршилтын хугацаагаар болон дагалдан ажилтны цалин тухайн албан тушаалын үндсэн цалингийн 60%-тай тэнцүү байна. Хийснээр цалинжих ажилтанд заалт хамаарахгүй” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Туршилтын хугацаагаар ажилласан 3 ажилтанд илүү олгосон 1,269,900.00 /Нэг сая хоёр зуун жаран есөн мянга есөн зуун/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн захирал Л.Цэнгүүнжав, нягтлан бодогч Ё.Мөнхбаяр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.АРИУНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315_Auditin_2_Gazar-17.Docx

001090233



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 398/А0150458
АХГ-2022/28/НА-СТА-ТВА.

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 2,135,498,600.00 төгрөгийн ажил, гүйлгээний 171 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 мэдээллийг хугацаа хоцроож, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3 "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн захирал Л.Цэнгүүнжав, Нягтлан бодогч Е.Мөнхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 399/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/28/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан орлогын төлөвлөгөө 10,172,319.98 төгрөг буюу 0.8 хувиар тасарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээний дагуу зорилтот түвшний хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн захирал Л.Цэнгүүнжав, Нягтлан бодогч Ё.Мөнхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Г.АРИУНБАТ